



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/107

Улаанбаатар хот

Худалдааны гудамж байгуулах ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 24/08 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.6 дахь зорилт, арга хэмжээг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Чингэлтэй дүүрэгт үйл ажиллагаа эрхэлдэг жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, айл өрх, ард иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, шинээр ажлын байрыг бий болгох, худалдаа үйлчилгээний соёлыг дээшлүүлэх, дүүргийн нутаг дэвсгэр дэх тохижилт, дэд бүтцийг сайжруулах зорилгоор 12, 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт "Худалдааны гудамж"-ийг байгуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:
Гишүүд:

Засаг даргын Орлогч
Дүүргийн менежер
Засаг даргын Тамгын газрын Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн дарга
Дүүргийн Газар зохион байгуулалтын албаны дарга
Дүүргийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвийн дарга

Нарийн
бичгийн дарга

Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга

2.Худалдааны гудамж байгуулах ажлын судалгаа хийх, ажлын төсөв, төлөвлөгөө гаргах, хэрэгжилтийг хангаж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллахыг Ажлын хэсэг (З.Бямбажав)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажлыг эрчимжүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Ж.Лхагвасүрэн)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.МАНДУУЛ

1525010364